



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар

A/33

Амардалай

Хорогдсон мал, амьтны сэг зэмийг
цуглуулж устгах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Мал эмнэлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалт, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 23 ны өдрийн 01 албан даалгавар, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын А/47 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/74 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Бэлчээр, уст цэг, усны эх булаг болон өвөлжөө, хаваржааны орчмын нутаг дэвсгэрт хорогдсон малын сэг зэмийг цуглуулж, устгах, халдваргүйтгэлийн ажлыг 03 дугаар сарын 15 наас 05 дугаар сарын 20 ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал /Засаг даргын орлогч/

Гишүүдэд: Д.Наранцэцэг /МЭТ-ийн дарга/

Б.Батжаргал /Дэлгэрбаяндалай нэгжийн эмч/

Б.Гарьдмагнай /ХААТ-ийн мэргэжилтэн/

П.Мөнхзориг /1-р багийн Засаг дарга/

Г.Сосорбурам /2-р багийн Засаг дарга/

Б.Баатарсүрэн /3-р багийн Засаг дарга/

Б.Дэлгэрсайхан /ЗДТГ-ын жолооч/

Б.Бямбадорж /ЗДТГ-ын гэрээт ажилтан/

Хоёр: Хорогдсон малын сэг зэмийг цуглуулж устгах, халдваргүйтгэлийн ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Гурав: Уг ажлыг зохион байгуулж устгах, халдваргүйтгэлийн ажлыг гүйцэтгэх хүн хүч, техник хэрэгсэлд шаардагдах зардалд дэмжлэг үзүүлж ажиллахыг ЗДТГ-ын дарга /С.Нарантунгалаг/-т даалгасугай.

Дөрөв: Гадны аймаг, сумдад оторлож байгаа малчид орон нутагруугаа нүүдэл хийхдээ хорогдсон малын сэг зэмийг цуглуулж устгах, халдваргүйтгэл хийлгэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Тав: Мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж, үр дүн, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллан, хийсэн ажлын тайлан мэдээг 2021 оны 05 дугаар сарын 18 ны дотор аймгийн ХОХБТХ-т хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч /Л.Золжаргал/ МЭТ-ийн дарга /Д.Наранцэцэг/, нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.БАЯРСҮХ

4880100098

